

ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ҮНЭ ЦЭНЭ

Б.ӨЛЗИЙСАЙХАН - МУИС-ийн НШУС-ийн Философийн салбарын магистрант

Түлхүүр үгс: Эрх чөлөө, сонголт, хариуцлага, ёс суртахуун, төгс индивидуал байдал.

Бидний амьдарч байгаа ардчилсан нийгэмд эрх чөлөөний асуудлыг хүн бүр ярьж, хэлэлцэн түүний тухай сайн мэддэг юм шиг байвч яг үнэндээ эрх чөлөө гэсэн ойлголтын жинхэнэ утга агуулгыг тэр бүр сайн мэдэхгүй байх хандлага ажиглагдсаар байна. Өнөөдөр Монголд хариуцлага гэдэг зүйл үнэ цэнээ алдсаар түүнийг хамгийн их ярьдаг хүмүүс хүртэл хамгийн их хариуцлага алддаг болсон. Гэтэл хариуцлага алдсан хүн бүртэй хариуцлага тооцож чадахгүй л байна. Хариуцлага тооцож чаддаг, шударга нийгмийг бий болгохын тулд Монгол хүн бүр эрх чөлөө, хариуцлагын үнэ цэнийг мэддэг, түүнийгээ ухамсрладаг байх хэрэгтэй. Үүний тулд эрх чөлөө гэж юу вэ?, эрх чөлөө нь сонголт, хариуцлага, ёс суртахуунтай хэрхэн холбогдох зэргийг нарийвчлан судлах шаардлага бидний өмнө тулгарч байна.

Эрх чөлөө гэж юу вэ?

Эрх чөлөө гэдэг бол жинхэнэ утгаараа бид өөрсдийн үйл хэргээ өөрсдийн хүслээр гүйцэтгэхдээ бусдын үйл хэргийг үгүйсгэхгүй, түүнд нь саад тотгор учруулахгүй байх явдал мөн.

Жон Стюарт Милль

Ф.Бастиа энэ асуултанд хариулахын тулд нэгэн алдарт аялагчид тохиолдсон явдлыг жишээ болгон ярьсан байдаг.

– Алдарт аялагч нэгэн өдөр дөнгөж саяхан хүүхэд мэндэлсэн зэрлэг хүмүүсийн омгийнхон дээр очиж гэнэлдээ. Янз бүрийн бугуйвч, дэгээ төмөр, утас зүүсэн мэргэч төлгөч, илбэ шидтэн, эмч домч нар дөнгөж төрсөн хүүхдийг хүрээлээд тойрон зогсч байсан гэнэ. Тэгээд нэг нь “Энэ хүүхдийн хамрын нүхийг нь томруулахгүй бол эв нэгдлийн бэлгэдэл болсон гаансны тамхины анхилуун үнэрийг хэзээ ч үнэртэж чадахгүй” гэж хэлжээ. Гэтэл нөгөө нь “Би энэ хүүхдийн чихийг мөр хүртэл нь сунгаж өгөхгүй бол хэзээ ч юм сонсож чадахгүй” гэж. Харин гурав дахь нь “Энэ хүүхдийн нүдийг томруулахгүй бол тэр хэзээ ч нарны

туяа үзэж чадахгүй нь” гэж. Дөрөв дэх нь “Хөлийг нь тэгшлэхгүй бол тэр хэзээ ч тэгш зогсч чадахгүй” гэжээ.

Гэтэл аялагч “Та нар болиоч ээ!” гэж хашгирдаг. “Бурхан яаж заяасан байна тэр нь л гайхамшигтай зүйл. Иймээс бие бялдрын дасгал, туршлага, эрх чөлөөгөөр нь наад хүүхдийнхээ бие эрхтэнг хөгжүүлж, эрүүл чийрэг бойжуулаач ээ!” гэж хэлдэг.⁹⁵

Энд гарч байгаа хамгийн чухал санаа бол эрх чөлөөний цаана хувь хүний чөлөөт сонголт, чөлөөт үйл ажиллагаа байдаг гэсэн санаа юм. Эрх чөлөө гэдэг бол хүн бүр бусдын оролцоогүйгээр өөрийн хийх зүйл, итгэж бишрэх зүйлээ сонгох чадвар билээ.⁹⁶ Хүмүүс эрхээс илүү эрх чөлөөнд дурладаг. Учир нь эрх хоол унд идэх, хувцас хунар өмсүүлэх гэх мэт хүний амьд явах эрхийг хэлбэр төдий хэрэгжүүлэхийн тулд өдөр бүр 1 өнгийн цамц өмсгөж, нэг янзын хоол идүүлэх аюултай учраас өөрийн хүссэн амьдралаараа амьдарч, юунд итгэж бишрэхээ өөрөө сонгож, өдөр бүр өөр өнгийн цамц өмсөхийн тулд хүмүүс эрх чөлөөнд хайртай байдаг.⁹⁷

Эрх чөлөө бол хязгаартай зүйл

Нэг хүний дур зорго нөгөө хүний дур зоргоор
хязгаарлагдаж буй тэр цэг дээр эрх чөлөө жинхэнэ
утгаараа оршдог

Иммануил Кант

Хэрвээ эрх чөлөө хязгааргүй байсан бол зөвхөн дур зорго л болж хувирах байсан. Энэ нь эзгүй арал дээрх Робинзон Крузотой адил. Эрх чөлөөг үнэ цэнэтэй утга учиртай болгож байгаа зүйл нь түүний хязгаарлалт юм. Эрх чөлөө бусдын амьдралд хөндлөнгөөс оролцохгүй байхыг бид бүхнээс шаарддаг. Тийм учраас чөлөөт сонголт нь хариуцлага, ёс суртахуун гэсэн хоёр чухал зүйлийг бий болгодог юм. Хүн төрлөхтний түүхэнд эрх чөлөө ёс суртахуун хоёрыг эрх чөлөө хариуцлага хоёрыг эсрэг тэсрэг зүйлс гэж үзэх хандлага байсан. Гэвч эрх чөлөө мөн чанараараа ёс суртахуун байдаг.⁹⁸

Эрх чөлөө мөн чанараараа ёс суртахуун болох нь. Маргарет Тетчер
ёс суртахууны гол цөм нь сонголт. Хэрэв сонголтгүй бол ёс суртахуун ч сайн

⁹⁵ Ф.Бастиа. Хууль. УБ., 2007. 87 дахь тал

⁹⁶ А.Камю. Миф о Сизифе. Бунтарь. Минск., 1998

⁹⁷ John S.Mill. On Liberty. Cambridge University Press., 1989

⁹⁸ Найжел Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. Нээлттэй академи. УБ., 2006. 48 дахь тал

сайхан, муу муухай ч үгүй байхсан. Сайн сайхан, муу муухай гэдэг ойлголт хүн зөвхөн сонгох эрхтэй байгаа нөхцөлд л утга учиртай байдаг. Тийм учраас эрх чөлөөнд суурилсан ёс суртахуун өөрөө хамгийн үнэ цэнэтэй.⁹⁹ (Ж. Буу барьсан хүн таныг нэг хүнд туслахыг тушаавал энд ёс суртахуун яригдахгүй. Харин та өөрийн хүслээр өөрийн сонголтоор туслах туслахгүйгээ шийдэх үед ёс суртахуун яригдана.) “Эрх чөлөөнөөс илүү эхлээд өмсөх хувцас, идэх хоол, орох орон хүнд хэрэгтэй” гэж К.Маркс үзсэн байдаг. Гэвч эрх чөлөө энэ бүхнийг бий болгодог.

Эрх чөлөө эрдэм мэдлэг, баялгийг бий болгодог. Жон Стюарт Милль хэдийгээр бид санал нийлэхгүй байгаа хэдий ч бусдын бодох, ярих, хийх зүйлийг хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнийг “toleration” буюу “хүлцэн тэвчихүй” гэж нэрлэсэн. Чөлөөт нийгэмд үзэл бодлын өрсөлдөөнд янз бүрийн санаа бодол, итгэл үнэмшил, мэдлэг шалгагдаж үнэн эсвэл худал хуурмаг нь тодорхой болж шигшигдэж байдаг. Тиймээс “Үнэн” худал хуурмагийг зайлуулдаг.¹⁰⁰ Үүнийг Английн философич Ж.С.Милль “Сэтгэх эрх чөлөө” хэмээн маш оновчтой томъёолсон. Тийм учраас “Би чиний хэлж байгаа зүйлийг чинь үзэн ядаж байна. Гэхдээ наад үгээ хэлэх эрхийг чинь би амиараа хамгаалах болно” гэж Францын философич Вольтер хэлсэн байдаг. Тэгэхээр эрх чөлөө бол хий хоосон зүйл биш. Харин урьдчилан төсөөлөөгүй, урьдчилан таамаглах боломжгүй зүйлийг ч хүлээн зөвшөөрдөг. Харин социализм нь эрх чөлөөний тугийн дор бүх нийтийн талархлыг олсон боловч нийгэм хувь хүмүүсийг нэгэн туйлын зорилгод нийцүүлэхийг оролддог нь шинэ үзэл санаа үүсэн гарч, шинэ зүйл бий болоход саад учруулдаг байсан.¹⁰¹

Эрх чөлөө бол хүний салшгүй шинж чанар . Эрх чөлөөний нэг чухал философи үндэслэл бол хүн бүр төгс индивидуал (Individualism) буюу тусдаа бие даасан байдаг гэсэн үзэл юм. Либертари үзэлтнүүд хувь хүнийг нийгмийн үндэс гэж үзээд хувь хүмүүс л сонголтоо хийж, өөрсдийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээдэг гэж тайлбарладаг.¹⁰² Харин экзистенциалист философийн төлөөлөгч Ж.П.Сартр хүн тус бүрийн өвдөх, гуниглах, баярлах гэх мэт мэдрэмжүүд, хүсэл мөрөөдөл, бодож сэтгэх нь ялгаатай бөгөөд үүнийг хүн бүр дотроо л субъектив байдлаар мэдэрдэг, бусад хүмүүс биднийг зөвхөн гадна

⁹⁹ Мөн тэнд. 49 дэх тал

¹⁰⁰ John S. Mill. On Liberty. Cambridge University Press., 1989

¹⁰¹ Ф.А.Хаек. Боолчлогдох зам. УБ., 2005. 27 дахь тал

¹⁰² Д.Боаз. Либертарианизм. УБ., 2005. 32 дахь тал

талаас маань л объектив байдлаар л хардаг гэж тайлбарладаг.¹⁰³ Тэгэхээр хэн ч танд ямар байгааг, та юу бодож байгааг таниас илүү мэдэхгүй, мөн бусдын юу мөрөөдөж, хүсэж байгааг тэднээс илүү хэн ч мэдэхгүй. Энэ л хүн тус бүрийн халдашгүй дархан байдал юм.

Эрх чөлөө нь ардчилал, энхтайван, шударга ёс, тэгш эрхийн үндэс суурь байдаг болохоор хөгжингүй нийгмийн хамгийн үнэ цэнэтэй, эрхэм зүйл нь байдаг. Эрх чөлөө л бидэнд сонгосон амьдралаараа амьдрах боломж олгодог. Гэхдээ эрх чөлөө бусдын амьдралд хөндлөнгөөс оролцохгүй байхыг бид бүхнээс шаарддаг. Үүгээрээ эрх чөлөө нь хувь хүн бүр хариуцлагатай амьдрахын нэр юм. Энэ утгаараа хувь хүний эрх чөлөө хөгжлийн хамгийн сайн гарц болж чадна. Эрх чөлөөнд суурилсан нийгэм бусад нийгмээс илүүтэй оюунлаг, бүтээлч, хариуцлагатай, шударга, нигүүлсэнгүй байдаг. Тийм учраас “Эрх чөлөөгөө ээжээсээ илүү хайрла!” гэж Далай Лам хэлсэн байдаг.

Гэвч эрх чөлөөний мөн чанар, үнэ цэнийг ойлгож ухаараагүй ард түмэн, улс оронд жинхэнэ ардчиллыг бий болгох боломжгүй юм. Тиймээс эрх чөлөөний мөн чанар, үнэ цэнийг хүмүүст байнга ойлгуулж, анхааруулж, тунхаглаж байх шаардлагатай. **Эцэст нь тэмдэглэхэд эрх чөлөө бол сонголт, хариуцлага, ёс суртахуун, эрдэм мэдлэг, баялаг юм.**

Summary

Freedom is the most valuable and respected mission of developed society and it is basics of democracy, peace, justice and equity. Only freedom gives us possibly to live by chosen life. But freedom requires from us don't obstruct others life. Therefore it's impossible to create democracy in a country where people don't aware value and nature of freedom.

In the end we can say freedom is choice, responsibility, morals, knowledge and wealth.

¹⁰³ Jean Paul Sartre. Existentialism and Human Emotions. New York., 1957

Ном зүй

1. Найжел Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. Нээлттэй академи. УБ., 2006
2. Ф.Бастиа. Хууль. УБ., 2007
3. Д.Боаз. Либертарианизм. УБ., 2005
4. Ф.А.Хаек. Боолчлогдох зам. УБ., 2005
5. А.Камю. Миф о Сизифе. Бунтарь. Минск., 1998
6. John S.Mill. On Liberty. Cambridge University Press., 1989
Jean Paul Sartre. Existentialism and Human Emotions. New York.,